

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

|       |  |    |
|-------|--|----|
| 1     | Аудитын гэрчилгээ.....   | 2  |
| 2     | Аудитын тайлан.....  | 4  |
| 2.1.  | Оршил.....   | 4  |
| 2.2.  | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....   | 4  |
| 2.3.  | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....  | 4  |
| 2.4.  | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин.....   | 5  |
| 2.5.  | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ..... | 5  |
| 2.6.  | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....   | 6  |
| 2.7.  | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....  | 6  |
| 2.8.  | Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....   | 6  |
| 2.9.  | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар тодруулга.....  | 7  |
| 2.10. | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....   | 7  |
| 2.11. | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....                                  | 7  |
| 2.12. | Шилэн дансны мэдээлэл.....   | 7  |
| 2.13. | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....  | 7  |
| 2.14. | Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....   | 8  |
| 3     | Менежментийн захидал.....  | 9  |
| 4     | Аудит хийсэн санхүүгийн тайлан.....  | 12 |
| 5     | Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....  | 16 |

## Товчилсон үгийн жагсаалт

|        |  |
|--------|--|
| АДБОУС | Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт |
| АОУС   | Аудитын олон улсын стандарт                      |
| НББ    | Нягтлан бодох бүртгэл                            |
| ХХОАТ  | Хувь хүний орлогын албан татвар                  |
| ААНОАТ | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар            |
| АХБ    | Азийн хөгжлийн банк                              |



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ЗҮҮН ӨМНӨД ГОВИЙН ХОТ  
БАЙГУУЛАЛТ, ХИЛИЙН ОЙРОЛЦОО  
СУУРИН ГАЗРУУДЫН ХӨГЖЛИЙН  
L3388-MON НЭМЭЛТ  
САНХҮҮЖИЛТИЙН ТӨСӨЛ I"-ИЙН  
ЗАХИРАЛ С.МАГНАЙСҮРЭН ТАНАА

2020 ОЧ. 21 № 06/1259  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3388-MON нэмэлт санхүүжилтийн төсөл I”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3388-MON нэмэлт санхүүжилтийн төсөл I”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайлан материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, үнэн, зөв бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3388-MON нэмэлт санхүүжилтийн төсөл I”-ийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн зохицуулагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3388-MON нэмэлт санхүүжилтийн **төсөл I**”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг төслийн захирал С.Магнайсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагнал, гэрээний үүргийн биелэлт, нотлох баримтын бүрдэлт, нэмэгдсэн өртгийн албан татварын баримт бүрдэлтийг хангаж ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3388-MON нэмэлт санхүүжилтийн **төсөл I**”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3388-MON нэмэлт санхүүжилтийн **төсөл I**”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3388-MON нэмэлт санхүүжилтийн **төсөл I**”-ийн зохицуулагч нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 4 дүгээр сарын 06-аас 2020 оны 4 дүгээр сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 20-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн “Грант Торнтон аудит” ХХК-ийн ахлах аудитор Л.Болорцэцэг, аудитор Ш.Оюунчимэг, туслах аудитор Э.Мэндсайхан нар Үндэсний аудитын газрын захиалгаар хариуцаж хэрэгжүүлэв.

“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3388-MON нэмэлт санхүүжилтийн төсөл I”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Грант Торнтон аудит” ХХК-д 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх

журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин**

Төслийн үндсэн зорилго нь бохир ус цэвэрлэх байгууламжийн шинэлэг технологи ашигласнаар байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө багасч, орон нутгийн оршин суугчдын эрүүл ахуйн орчны стандартыг дээшлүүлэх явдал юм.

Буцалтгүй тусламжийн төсөл амжилттай хэрэгжиж, Засгийн газрын дэмжлэг болон төслийн удирдах нэгжийг үргэлжлүүлэн ажлуулсаны үр дүнд нэмэлт санхүүжилтийн төслийн зээл богино хугацаанд Монгол Улсын Их хурлаар батлагдаж хүчин төгөлдөр болсон байна.

Нэмэлт санхүүжилтийн төсөл нь 2030 он хүртэлх Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын Байгаль орчны тогтвортой хөгжлийн зорилгод заасан Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны ус хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, томоохон хот суурин газруудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан цэвэрлэх байгууламжийг үе шаттай шинэчлэх ажлуудыг хийхэд хувь нэмэр оруулж байна.

Өвөрхангай аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн барилгын ажлыг 2019 оны 11 дүгээр сарын 15-нд, Архангай аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн барилгын ажлыг 2019 оны 10 дугаар сарын 15-нд бохир ус цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулсан байна.

Тус төслийн нийт өртөг Азийн хөгжлийн банкнаас 19,430.0 мянган ам.доллар, Монгол Улсын Засгийн Газраас 1,740.0 мянган ам.долларын тус тус оролцоотойгоор хэрэгжиж байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3388-MON нэмэлт санхүүжилтийн төсөл I”-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогогүй боловч нягтлан бодох бүртгэлээ хөтлөхдөө Сангийн сайдын 2007 оны 326 тоот тушаалаар батлагдсан *“Хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагаас Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй зээлийн болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, Засгийн газрын тусгай сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар”*, санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан *“Санхүүгийн тайлангийн тодруулгыг бэлтгэх үлгэрчилсэн загвар”*-ыг дагаж мөрдөж байгаа нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3388-MON нэмэлт санхүүжилтийн төсөл I” нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн программ хангамж ашигладаггүй, хэрэглээний “Microsoft Excel” программ хангамж ашигладаг байна.

Төслийн удирдах нэгжийн үйл ажиллагааг Сангийн Сайдын 2015 оны 7 дугаар сарын 10-ны 196 дугаар тушаалаар удирдан чиглүүлж байна.

“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3388-MON нэмэлт санхүүжилтийн төсөл I”-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд

“бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөтэй” гэж үзлээ.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3388-MON нэмэлт санхүүжилтийн төсөл I”-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төслийн гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайланд холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,879,215.0 мянган төгрөгөөс тооцон 18,792.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг өөрчлөөгүй.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3388-MON нэмэлт санхүүжилтийн төсөл I”-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтүүд дараах байдалтай байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл      | Эцсийн үлдэгдэл     | Өсөлт/бууралт       |
|---|---------------------|---------------------|---------------------|
| Б   | 1                   | 2                   | 3=2-1               |
| Мөнгөн хөрөнгө                                    | 3,570,295.0         | 3,091,363.7         | (478,931.4)         |
| Авлага  | 210.4               | 530.6               | 320.2               |
| Урьдчилж төлсөн зардал                            | 1,055,163.5         | -                   | (1,055,163.4)       |
| Бусад эргэлтийн хөрөнгө                           | -                   | 28,352,700.3        | 28,353,700.0        |
| Үндсэн хөрөнгө                                    | 11,018,603.3        | 4,130.9             | (11,014,472.4)      |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>15,644,272.2</b> | <b>31,448,725.5</b> | <b>15,804,453.3</b> |
| Өр төлбөр   | 25,702,590.5        | 3,575,821.5         | 22,126,769.0        |
| Хуримтлагдсан үр дүн                              | (10,058,318.3)      | 27,872,904.0        | 37,931,222.3        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>15,644,272.2</b> | <b>31,448,725.5</b> | <b>15,804,453.3</b> |

Тайлант онд бусад эргэлтийн хөрөнгө, өр төлбөр дансанд материаллаг үлдэгдэлтэй байна. Тухайлбал:

Бусад эргэлтийн хөрөнгө дансанд Архангай, Өвөрхангай, Дорноговь, Өмнөговь аймгийн төвийн цэвэрлэх байгууламж барихаар гэрээ байгуулсан “Комфорт импэкс” ХХК, “ЧММ” ХХК, “Эйч Эн Чи Барилга” ХК, “Н Эй Би” ХХК, “Сан” ХХК, Зэт ХХК-д шилжүүлсэн гэрээт ажлын гүйцэтгэл тайлант онд нийт 28,352,700.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансанд Архангай, Өмнөговь, Өвөрхангай аймгуудад баригдаж буй цэвэрлэх байгууламжийн гэрээт ажлын гүйцэтгэлээс суутган тооцсон барьцаа болон Дорноговь аймгийн төвд баригдаж буй ажлын гүйцэтгэлийн өглөг тайлант онд 22,126,122.3 мянган төгрөгөөр буурсан байна.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3388-MON нэмэлт санхүүжилтийн төсөл I”-ийг хэрэгжүүлэхэд зориулан нийт 16,052,500.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Нийт зардлыг Азийн Хөгжлийн банкнаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Төслийн мөнгөн хөрөнгө дансанд гүйцэтгэлээр 12,835,388.7 мянган төгрөгийг Азийн хөгжлийн банкнаас авч, бусад орлого 500.0 мянган төгрөг, харилцах дансны хүүгийн орлого 37,653.0 мянган төгрөг нийт 12,873,041.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 12,384,033.3 мянган төгрөгийг зарцуулж, 37,653.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, 3,091,364.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

## **2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж нийт 12 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1,268,917.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1,268,917.0 мянган төгрөгийн алдааг залруулж, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой 3 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа. Үүд:

1. Архангай, Өвөрхангай аймгийн төвд баригдаж буй цэвэрлэх байгууламжийн ажлын гүйцэтгэл 1,268,917.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" заалтад нийцээгүй, үнэлгээ ба хувиарлалт, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал гараагүй.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3388-MON нэмэлт санхүүжилтийн төсөл I”-ийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

## **2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгсөнийг хэрэгжүүлж ажилласан байна.



#### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3388-MON нэмэлт санхүүжилтийн төсөл I”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3388-MON нэмэлт санхүүжилтийн төсөл I”-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3388-MON нэмэлт санхүүжилтийн төсөл I”-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1. Гэрээний үүргийн биелэлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

##### 3.1.1 Илрүүлэлт

“Эйч Эн Си Констракшн” ХК нь Дорноговь аймгийн төвийн цэвэрлэх байгууламж, 4.4 км бохирын коллекторын шугам болон бусад туслах үйлчилгээ”-ний ажлын гүйцэтгэгчээр сонгогдон 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 2018/266 тоот “Ажил гүйцэтгэх” гэрээг монгол төгрөгөөр Барилга хот байгуулалтын яамтай байгуулсан байна. Тус компани нь гүйцэтгэсэн ажлын төлбөр болох 2,483,108.0 мянган төгрөгийг нэхэмжлэхдээ гэрээний ерөнхий нөхцлийн 55.1-д “Хуулийн дагуу Монгол банкнаас албан ёсоор зөвшөөрсөн тохиолдолд төлбөрийг төгрөгөөс бусад мөнгөн тэмдэгтээр хийх бол төлбөрийн дүнг тооцоходоо тендер зарласан өдрийн Монгол банкны ханшийг ашиглана” заалтыг үндэслэн ам.доллараар авах хүсэлтийг ирүүлснээр маргаан үүсч, эцэслэн шийдвэрлэгдээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.2 дахь хэсэгт “Улсын болон орон нутгийн төсөвт төлөх, төсвөөс санхүүжүүлэх аливаа төлбөр тооцоог зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх бөгөөд эдгээр төлбөр тооцоог гадаад валютаар хийхийг хорглоно” заалтад нийцэхгүй байна.

##### 3.1.2 Эрсдэл

Гэрээний үүргийн биелэлт хангагдахгүй үргүй зардал үүсэх, валютын ханшийн зөрүүний алдагдал хүлээх эрсдэлтэй байна.

##### 3.1.3 Өгсөн зөвлөмж

Ажил үйлчилгээний гэрээг байгуулахдаа Монгол Улсын хууль, журмыг үндэслэх, гэрээт ажил үйлчилгээний биелэлтийг хангаж, хууль журмын дагуу шийдвэрлүүлэх,

##### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

*Монгол төгрөгөөр гүйцэтгэлийг нь санхүүжүүлэх тухай БХБЯ-ны удаа дараагийн шийдвэрийг “Эйч Эн Си” ХХК нь хүлээн авахгүй байгаа тул Барилга Хот Байгуулалтын Яам санаачлан гэрээнд заасны дагуу Худалдаа аж үйлдвэрийн танхимд маргаан таслагчийг ажиллуулах тухай хүсэлт гаргаж, маргаан таслагчийг томилуулаад байна.*

## **3.2. Нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой асуудал**

### **3.2.1 Илрүүлэлт**

Төсөл хэрэгжүүлэх нэгж нь төлбөрийн баримтыг худалдан авагч нараас шаардаж, анхан шатны баримтандаа хавсаргаагүй нь албан татвар суутган төлөгч буюу тус төсөл хэрэгжүүлэгч нэгжийн харилцагч, бэлтгэн нийлүүлэгч байгууллагууд нь санхүүгийн болон татварын тайланд орлогоо тусгахгүй байх, орлогоо нуун дарагдуулах боломжийг бүрдүүлж байна. Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйл 17.6 “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” гэсэн заалтад нийцэхгүй байна.

### **3.2.2 Эрсдэл**

Харилцагч байгууллагууд санхүүгийн болон татварын тайланд орлогоо тайлагнахгүй нуун дарагдуулах эрсдэлтэй

### **3.2.3 Өгсөн зөвлөмж**

Ажил үйлчилгээний төлбөр тооцоог хийхдээ гүйцэтгэгч байгууллага төлбөрөө татварын системд шивж оруулсан баримтыг үндэслэн төлбөр тооцоог гүйцэтгэж байх

### **3.2.4 Байгууллагын өгсөн хариу, тайлбар**

*Барилгын ажил, үйл ажиллагааны зардлын Засгийн газрын санхүүжилтийг сар бүр e-tax.mta.mn сайтаас татан авч, Татварын ерөнхий газарт хүргүүлж баталгаажуулдаг НӨАТ-ын Худалдан авалтын бүртгэлтэй тулган баталгаажуулж гүйлгээ тус бүрээр бүртгэл хөтөлдөг. Төслийн хэрэгцээнд буй санхүүгийн програмд энэхүү бүртгэлийг нэмж оруулахаар нийлүүлэгч компанитай хамтран ажиллахаар төлөвлөж байна.*

## **3.3. Нягтлан бодох бүртгэл хөтөлөлттэй холбоотой асуудал**

### **3.3.1 Илрүүлэлт**

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн программ хангамж ашигладаггүй, хэрэглээний “Microsoft Excel” программаар нягтлан бодох бүртгэлээ хөтлөхдөө ерөнхий журналын бүртгэлийг ажил гүйлгээ тус бүрээр хөтөлдөггүй, зардлыг бөөн дүнгээр бүртгэж байна.

### **3.3.2 Эрдэл**

Нягтлан бодох бүртгэл дутуу хөтлөгдөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

### **3.3.3 Өгсөн зөвлөмж**

Үйл ажиллагаандаа тохирох санхүүгийн программаар нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв дэлгэрэнгүй хөтлөх.

### 3.3.4 Байгууллагын өгсөн хариу, тайлбар

*Төслийн удирдах нэгжийн хэрэгцээнд буй Санхүүгийн програм нь төслийн тайлан бүртгэлийн шаардлагад бүрэн нийцэхгүй, цаг авсан, олон төслийн санхүүгийн бүхий л үйл ажиллагааг хариуцан ачаалалтай ажиллаж байгаа санхүүгийн ажилтанд нэмэлт ажил болдог тул зарим шаардлагатай бүртгэлийг эксел програмаар бэлтгэдэг. Санхүүгийн програмыг сайжруулах талаар нийлүүлэгч компанитай хамтарч ажиллах төлөвлөгөөтэй байна.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 7 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөг)

| Дансны код  | Балансын үзүүлэлт                          | Эхний үлдэгдэл            | Эцсийн үлдэгдэл          |
|-------------|--|---------------------------|--------------------------|
| <b>1</b>    | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>             | <b>4,625,668,916.16</b>   | <b>31,163,369,321.84</b> |
| <b>31</b>   | <b>Мөнгөн хөрөнгө</b>                      | <b>3,570,295,034.76</b>   | <b>3,091,363,679.75</b>  |
| <b>311</b>  | <b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>          | <b>517,203.64</b>         | <b>9,551.64</b>          |
| 31110       | Төгрөг                                     | 517,203.64                | 9,551.64                 |
| <b>312</b>  | <b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>          | <b>3,569,777,831.12</b>   | <b>3,091,354,128.11</b>  |
| <b>3121</b> | <b>Төгрөг</b>                              | <b>9,213,568.73</b>       | <b>1,417,867,352.35</b>  |
| 31211       | Төрийн сангийн харилцах                    | 9,195,619.26              | 1,417,867,269.39         |
| 31213       | Арилжааны банк дахь харилцах               | 17,949.47                 | 82.96                    |
| <b>3122</b> | <b>Гадаад валют</b>                        | <b>3,560,564,262.39</b>   | <b>1,673,486,775.76</b>  |
| 31223       | Арилжааны банк дахь харилцах               | 3,560,564,262.39          | 1,673,486,775.76         |
| <b>33</b>   | <b>Авлага</b>                              | <b>210,426.67</b>         | <b>530,640.00</b>        |
| 3351        | Байгууллагаас авах авлага                  | 210,426.67                | 530,640.00               |
| <b>34</b>   | <b>Урьдчилгаа</b>                          | <b>1,055,163,454.7</b>    | <b>-</b>                 |
| 34600       | Урьдчилж гарсан зардал                     | 1,055,163,454.7           | -                        |
| <b>35</b>   | <b>Нөөцийн бараа</b>                       | <b>-</b>                  | <b>28,352,700,347.34</b> |
| 36800       | Бусад эргэлтийн хөрөнгө                    | -                         | 28,352,700,347.34        |
| <b>2</b>    | <b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>         | <b>11,018,603,307.9</b>   | <b>4,130,866.67</b>      |
| <b>39</b>   | <b>Үндсэн хөрөнгө</b>                      | <b>11,018,603,307.9</b>   | <b>4,130,866.67</b>      |
| <b>392</b>  | <b>Биет хөрөнгө</b>                        | <b>961,125.0</b>          | <b>704,825.00</b>        |
| 39205       | Машин тоног төхөөрөмж (компьютер)          | 1,281,500.0               | 1,281,500.00             |
| 39206       | Хуримтлагдсан элэгдэл                      | (320,375.0)               | (576,675.00)             |
| <b>393</b>  | <b>Биет бус хөрөнгө</b>                    | <b>5,213,541.7</b>        | <b>3,426,041.7</b>       |
| 39301       | Программ хангамж                           | 7,150,000.0               | 7,150,000.00             |
| 39302       | Хуримтлагдсан элэгдэл                      | (1,936,458.3)             | (3,723,958.33)           |
| <b>394</b>  | <b>Бусад хөрөнгө /ТӨҮГ/</b>                | <b>11,012,428,641.3</b>   | <b>-</b>                 |
| 39405       | Бусад эргэлтийн бус хөрөнгө                | 11,012,428,641.3          | -                        |
| <b>3</b>    | <b>Нийт хөрөнгийн дүн</b>                  | <b>15,644,272,224.1</b>   | <b>31,448,725,533.76</b> |
| <b>4</b>    | <b>Нийт өр төлбөр</b>                      | <b>25,702,590,479.4</b>   | <b>3,575,821,502.08</b>  |
| <b>41</b>   | <b>Богино хугацаат өр төлбөр</b>           | <b>25,702,590,479.4</b>   | <b>3,575,821,502.08</b>  |
| <b>413</b>  | <b>Өглөг</b>                               | <b>25,702,590,479.4</b>   | <b>3,575,821,502.08</b>  |
| 41361       | Байгууллагад төлөх өглөг                   | 25,631,680,935.8          | 3,575,821,502.08         |
| 41362       | Хувь хүмүүст төлөх өглөг                   | 70,909,543.6              | -                        |
| <b>5</b>    | <b>Цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>            | <b>(10,058,318,255.3)</b> | <b>27,872,904,031.68</b> |
| <b>51</b>   | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>         | <b>(10,058,318,255.3)</b> | <b>27,872,904,031.68</b> |
| <b>512</b>  | <b>Хуримтлагдсан үр дүн</b>                | <b>(10,058,318,255.3)</b> | <b>27,872,904,031.68</b> |
| 51210       | Өмнөх үеийн үр дүн                         | 1,896,003,804.7           | 15,278,725,697.40        |
| 51220       | Тайлант үеийн үр дүн                       | (11,954,322,060.0)        | 12,594,178,334.27        |
| <b>6</b>    | <b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>15,644,272,224.1</b>   | <b>31,448,725,533.76</b> |

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөг)

| Дансны код  | Үзүүлэлт   | Өмнөх он                   | Тайлант он               |
|-------------|--|----------------------------|--------------------------|
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>                               | <b>14,765,507,354.25</b>   | <b>14,441,832,766.80</b> |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>   | <b>14,765,507,354.25</b>   | <b>14,441,832,766.80</b> |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>                                   | <b>14,765,507,354.25</b>   | <b>14,441,832,766.80</b> |
| 120002      | Хүүгийн орлого   | 31,283,693.07              | -                        |
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого                                     | 14,725,223,661.18          | 14,441,332,766.80        |
| 1200042     | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            | -                          | 37,652,678.51            |
| 1200044     | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих                                      | 14,200,567,682.31          | 12,835,388,751.92        |
| 1200045     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого                                    | 524,655,978.87             | 1,568,291,336.37         |
| 120009      | Бусад орлого   | 9,000,000.00               | 500,000.00               |
| <b>2</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>                                   | <b>26,805,123,387.23</b>   | <b>1,879,214,969.08</b>  |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>26,805,123,387.23</b>   | <b>1,879,214,969.08</b>  |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                               | <b>26,737,415,466.29</b>   | <b>1,841,562,290.57</b>  |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | <b>80,483,157.00</b>       | <b>66,000,000.00</b>     |
| 210304      | Байрны түрээс  | 80,483,157.00              | 66,000,000.00            |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | <b>23,048,303,114.27</b>   | <b>15,355,656.49</b>     |
| 210401      | Бичиг хэрэг  | 2,588,365.27               | 4,197,863.94             |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 8,388,796.05               | 7,597,559.14             |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 1,918,796.20               | 3,560,233.41             |
| 210409      | Бараа материал шилжүүлсний зардал                                    | 23,035,407,156.75          | -                        |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>  | <b>24,030,950.00</b>       | <b>36,826,205.00</b>     |
| 210702      | Дотоод албан томилолт  | 24,030,950.00              | 36,826,205.00            |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | <b>3,042,851,929.69</b>    | <b>1,705,099,896.97</b>  |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,042,661,523.29           | 1,685,056,038.33         |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | -                          | 19,769,467.54            |
| 210808      | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж                   | 190,406.40                 | 274,391.10               |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | <b>541,746,315.33</b>      | <b>18,280,532.11</b>     |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 539,702,515.33             | 16,236,732.11            |
| 210903      | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол                                   | 2,043,800.00               | 2,043,800.00             |
| <b>211</b>  | <b>ХҮҮ</b>   | <b>67,707,920.94</b>       | <b>-</b>                 |
| <b>2111</b> | <b>Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр</b>                            | <b>67,707,920.94</b>       | <b>-</b>                 |
| 211101      | Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр                                   | 67,707,920.94              | -                        |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>-</b>                   | <b>37,652,678.51</b>     |
| <b>2133</b> | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>                   | <b>-</b>                   | <b>37,652,678.51</b>     |
| 213306      | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг                          | -                          | 37,652,678.51            |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>                            | <b>(12,039,616,032.98)</b> | <b>12,562,617,797.72</b> |
| <b>145</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>                               | <b>85,293,972.99</b>       | <b>31,560,536.56</b>     |
| 145001      | Гадаад валютын ханшийн зөрүүний олз                                  | 85,293,972.99              | 31,560,536.56            |
| <b>4</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>                      | <b>85,293,972.99</b>       | <b>31,560,536.56</b>     |
| <b>5</b>    | <b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>                                       | <b>(11,954,322,059.99)</b> | <b>12,594,178,334.27</b> |

#### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөг)

| Дансны код  | Үзүүлэлт   | Өмнөх он                   | Тайлант он                 |
|-------------|--|----------------------------|----------------------------|
|             | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>                                |                            |                            |
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>                        | <b>14,173,143,454.44</b>   | <b>12,873,541,430.42</b>   |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>   | <b>14,173,143,454.44</b>   | <b>12,873,541,430.42</b>   |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>                                   | <b>14,173,143,454.44</b>   | <b>12,873,541,430.42</b>   |
| 120002      | Хүүгийн орлого   | 31,283,693.07              | -                          |
| 120004      | <b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>                              | <b>14,132,859,761.37</b>   | <b>12,873,041,430.42</b>   |
| 1200042     | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            | -                          | 37,652,678.51              |
| 1200044     | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих                                      | 14,132,859,761.37          | 12,835,388,751.92          |
| 1200045     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого                                    | 524,655,978.87             | -                          |
| 120009      | Бусад орлого   | 9,000,000.00               | 500,000.00                 |
| <b>2</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>                         | <b>9,106,451.86</b>        | <b>1,868,071,088.71</b>    |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>9,106,451.86</b>        | <b>1,868,071,088.71</b>    |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                               | <b>9,106,451.86</b>        | <b>1,830,418,410.20</b>    |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                             | <b>-</b>                   | <b>-</b>                   |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | <b>-</b>                   | <b>60,000,000.00</b>       |
| 210304      | Байрны түрээс  | -                          | 60,000,000.00              |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | <b>-</b>                   | <b>14,797,364.00</b>       |
| 210401      | Бичиг хэрэг  | -                          | 3,907,809.37               |
| 210402      | Тээвэр, шатахуун   | -                          | 7,649,808.82               |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | -                          | 3,239,745.81               |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>  | <b>-</b>                   | <b>36,826,205.00</b>       |
| 210702      | Дотоод албан томилолт  | -                          | 36,826,205.00              |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | <b>190,406.40</b>          | <b>1,703,302,672.65</b>    |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | -                          | 1,685,056,038.33           |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | -                          | 17,972,243.22              |
| 210808      | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж                   | 190,406.40                 | 274,391.10                 |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | <b>8,916,045.46</b>        | <b>15,492,168.55</b>       |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 8,916,045.46               | 15,492,168.55              |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>-</b>                   | <b>37,652,678.51</b>       |
| <b>2133</b> | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>                   | <b>-</b>                   | <b>37,652,678.51</b>       |
| 213306      | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг                          | -                          | 37,652,678.51              |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>              | <b>14,164,037,002.58</b>   | <b>11,005,470,341.71</b>   |
| <b>23</b>   | <b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>                    | <b>12,566,821,278.81</b>   | <b>11,515,962,233.27</b>   |
| 230001      | Эргэж төлөгдөх зээл  | -                          | 11,515,962,233.27          |
| 232001      | Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл                              | 12,566,821,278.81          | -                          |
| <b>25</b>   | <b>Санхүүгийн үйл ажиллагааны зардал</b>                             | <b>(85,293,972.99)</b>     | <b>(31,560,536.55)</b>     |
| 250001      | Гадаад валютын ханшийн зөрүү   | (85,293,972.99)            | (31,560,536.55)            |
| <b>7</b>    | <b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>               | <b>(12,481,527,305.82)</b> | <b>(11,484,401,696.73)</b> |
| <b>8</b>    | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>                     | <b>1,682,509,696.76</b>    | <b>(478,931,355.01)</b>    |
| <b>9</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>              | <b>1,887,785,338.00</b>    | <b>3,570,295,034.76</b>    |
| <b>10</b>   | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>             | <b>3,570,295,034.76</b>    | <b>3,091,363,679.75</b>    |

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөг)

| Код        | Үзүүлэлт   | Хуримтлагдсан дүн          | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|------------|--|----------------------------|--|
| C01        | <b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>                 | 1,896,003,804.66           | 1,896,003,804.66                       |
| C07        | Тайлант үеийн үр дүн   | (11,954,322,059.99)        | (11,954,322,059.99)                    |
| <b>C08</b> | <b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>                 | <b>(10,058,318,255.33)</b> | <b>(10,058,318,255.33)</b>             |
| <b>D02</b> | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт алдааны залруулга | 25,337,043,952.72          | <b>25,337,043,952.72</b>               |
| <b>D03</b> | <b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>                            | <b>15,278,725,697.40</b>   | <b>15,278,725,697.40</b>               |
| D08        | Тайлант үеийн үр дүн   | 12,594,178,334.27          | 12,594,178,334.27                      |
| <b>D09</b> | <b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>                 | <b>27,872,904,031.68</b>   | <b>27,872,904,031.68</b>               |



#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөг)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт   | Батлагдсан төлөвлөгөө   | Гүйцэтгэл               | Зөрүү                  | Хувь         |
|-----------------------|--|-------------------------|-------------------------|------------------------|--------------|
| 1                     | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>              |                         |                         |                        |              |
| 2                     | <b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>                             | <b>16,052,500,000.0</b> | <b>13,346,380,643.5</b> | <b>2,706,119,356.5</b> | <b>83.1</b>  |
| 21                    | <b>Урсгал зардал</b>   | <b>2,420,000,000.0</b>  | <b>1,830,418,410.2</b>  | <b>589,581,589.8</b>   |              |
| 210                   | <b>Бараа, ажил үйлчилгээний зардал</b>                               | <b>2,420,000,000.0</b>  | <b>1,830,418,410.2</b>  | <b>589,581,589.8</b>   |              |
| 2103                  | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | <b>61,000,000.0</b>     | <b>60,000,000.0</b>     | <b>1,000,000.0</b>     | <b>98.4</b>  |
| 210304                | Байрны түрээс  | 61,000,000.0            | 60,000,000.0            | 1,000,000.0            | 98.4         |
| 2104                  | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | <b>22,909,000.0</b>     | <b>14,797,364.0</b>     | <b>8,111,636.0</b>     | <b>214.0</b> |
| 210401                | Бичиг хэрэг  | 5,160,000.0             | 3,907,809.4             | 1,252,190.6            | 75.7         |
| 210402                | Тээвэр, шатахуун   | 13,849,000.0            | 7,649,808.8             | 6,199,191.2            | 55.2         |
| 210403                | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 3,900,000.0             | 3,239,745.8             | 660,254.2              | 83.1         |
| 2106                  | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | <b>880,000.0</b>        | -                       | <b>880,000.0</b>       | -            |
| 210603                | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл   | 880,000.0               | -                       | 880,000.0              | -            |
| 2107                  | <b>Томилолт, зочны зардал</b>  | <b>40,519,500.0</b>     | <b>36,826,205.0</b>     | <b>3,693,295.0</b>     | <b>90.9</b>  |
| 210702                | Дотоод албан томилолт  | 40,519,500.0            | 36,826,205.0            | 3,693,295.0            | 90.9         |
| 2108                  | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | <b>2,279,091,500.0</b>  | <b>1,703,302,672.7</b>  | <b>575,788,827.3</b>   | <b>74.7</b>  |
| 210801                | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,279,091,500.0         | 1,703,302,672.7         | 575,788,827.3          | 74.7         |
| 2109                  | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | <b>15,600,000.0</b>     | <b>15,492,168.6</b>     | <b>107,831.4</b>       | <b>99.3</b>  |
| 210901                | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 15,600,000.0            | 15,492,168.6            | 107,831.4              | 99.3         |
| 23                    | <b>Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл</b>                    | <b>13,632,500,000.0</b> | <b>11,515,962,233.3</b> | <b>2,116,537,766.7</b> | <b>84.5</b>  |
| 230001                | Эргэж төлөгдөх зээл  | 13,632,500,000.0        | 11,515,962,233.3        | 2,116,537,766.7        | 84.5         |
|                       | <b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>                                | <b>16,052,500,000.0</b> | <b>12,835,388,751.9</b> | <b>3,217,111,248.1</b> | <b>80.0</b>  |
| 120004                | <b>Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас</b>                         | <b>16,052,500,000.0</b> | <b>12,835,388,751.9</b> | <b>3,217,111,248.1</b> | <b>80.0</b>  |
| 1200044               | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих                                      | 16,052,500,000.0        | 12,835,388,751.9        | 3,217,111,248.1        | 80.0         |
| 4                     | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>              |                         | 3,570,295,034.8         |                        |              |
| 5                     | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>             |                         | 3,059,303,143.2         |                        |              |

**5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

|                                     |                |  |                                    |                     |                         |
|-------------------------------------|----------------|--|------------------------------------|---------------------|-------------------------|
| <b>Огноо:</b>                       | <b>2019 он</b> | <b>Аудитын н нэр:</b>  | <b>Санхүүгийн тайлангийн аудит</b> | <b>Аудитын код:</b> | САГ-2020/736/СТА-ТХН    |
| <b>Шалгагдсан байгууллагын нэр:</b> |                | <b>Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн L3388-MON төсөл</b> |                                    |                     | <b>мянган төгрөгөөр</b> |

| №        | Алдаа, зөрчлийн товч утга   | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан |                      |
|----------|---|------------|---------------------------------------|--|----------------------|
|          |   |            | Нэр                                   | Албан тушаал                                     | Овог нэр             |
| <b>A</b> | <b>1</b>  | <b>2</b>   | <b>3</b>                              | <b>4</b>   | <b>5</b>             |
| 1        | “Эйч Эн Си Констракшн” ХК нь Дорноговь аймгийн төвийн цэвэрлэх байгууламж, 4.4 км бохирын коллекторын шугам болон бусад туслах үйлчилгээ”-ний ажлын гүйцэтгэгчээр сонгогдон 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 2018/266 тоот “Ажил гүйцэтгэх” гэрээг монгол төгрөгөөр Барилга хот байгуулалтын яамтай байгуулсан байна. Тус компани нь гүйцэтгэсэн ажлын төлбөр болох 2,483,108.0 мянган төгрөгийг нэхэмжлэхдээ гэрээний ерөнхий нөхцлийн 55.1-д “Хуулийн дагуу Монгол банкнаас албан ёсоор зөвшөөрсөн тохиолдолд төлбөрийг төгрөгөөс бусад мөнгөн тэмдэгтээр хийх бол төлбөрийн дүнг тооцохдоо тендер зарласан өдрийн Монгол банкны ханшийг ашиглана” заалтыг үндэслэн ам.доллараар авах хүсэлтийг ирүүлснээр маргаан үүсч, эцэслэн шийдвэрлэгдээгүй байна. |            | Зөвлөмж өгөх                          | Төслийн зохицуулагч                              | Б.Оюун               |
| 2        | Төсөл хэрэгжүүлэх нэгж нь төлбөрийн баримтыг худалдан авагч нараас шаардаж, анхан шатны баримтандаа хавсаргаагүй нь албан татвар суутган төлөгч буюу тус төсөл хэрэгжүүлэгч нэгжийн харилцагч, бэлтгэн нийлүүлэгч байгууллагууд нь санхүүгийн болон татварын тайланд орлогоо тусгахгүй байх, орлогоо нуун дарагдуулах боломжийг бүрдүүлж байна.   |            | Зөвлөмж өгөх                          | Нягтлан бодогч                                   | Ч.Одонтуяа           |
| 3        | Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн программ хангамж ашиглдаггүй, хэрэглээний “Microsoft Excel” программаар нягтлан бодох бүртгэлээ хөтлөхдөө ерөнхий журналын бүртгэлийг ажил гүйлгээ тус бүрээр хөтөлдөггүй, зардлыг бөөн дүнгээр бүртгэж байна.  |            | Зөвлөмж өгөв                          | Нягтлан бодогч<br>Төслийн зохицуулагч            | Ч.Одонтуяа<br>Б.Оюун |



